

БАТЛАВ.
ЗАМ, ТЭЭВРИЙН
ХӨГЖЛИЙН ГАЙД

С.БЯМБАЦОГТ

БАТЛАВ.
ГАДААД ХАРИЛЦААНЫ
САЙД

Б.БАТЦЭЦЭГ

БАТЛАВ.
ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД
ХЭРГИЙН САЙД

Х.НЯМБААТАР

**"ОЛОН УЛСЫН ИРГЭНИЙ НИСЭХИЙН ЭСРЭГ ХУУЛЬ БУС ҮЙЛДЭЛТЭЙ ТЭМЦЭХ
ТУХАЙ КОНВЕНЦ"-Д НЭГДЭН ОРСНЫГ СОЁРХОН БАТЛАХ ТУХАЙ
ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ**

Нэг. Хуулийн төсөл боловсруулах үндэслэл, шаардлага

1.1. Хууль зүйн үндэслэл:

Монгол Улсын Их Хурлын 2021 оны 12 дугаар тогтоолоор баталсан "Монгол Улсын Хууль тогтоомжийг 2024 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл"-ийн 125-д "Олон улсын иргэний нисэхийн эсрэг хууль бус үйлдэлтэй тэмцэх тухай конвенц"-д нэгдэн орсныг соёрхон батлах тухай хуулийн төслийг 2022 онд өргөн мэдүүлэхээр тусгасан.

Монгол Улс "Иргэний нисэхийн аюулгүй байдлын эсрэг хууль бус үйлдлийг хориглох тухай" Монреалийн конвенцод 1972 оны 09 дүгээр сарын 14-ний өдөр нэгдэн орсон.

Иргэний нисэхийн эсрэг шинэ төрлийн аюул занал, хууль бус үйлдлээс урьдчилан сэргийлэх, тэмцэх илүү үр дүнтэй арга хэмжээ авахад чиглэсэн олон улсын эрх зүйн хэм хэмжээг бэхжүүлэх зорилгоор 2010 оны 08 дугаар сарын 30-наас 09 дүгээр сарын 10-ны өдөр Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Бэзжин хотноо зохион байгуулсан Нисэхийн аюулгүй байдлын Дипломат бага хурлаас "Олон улсын иргэний нисэхийн эсрэг хууль бус үйлдэлтэй тэмцэх тухай конвенц"-ыг баталсан.

"Олон улсын иргэний нисэхийн эсрэг хууль бус үйлдэлтэй тэмцэх тухай конвенц"-д нислэгийн аюулгүй байдал, агаарын хелгээ, агаарын навигацийн тоног төхөөрөмжид гэмтэл, аюул учруулах, ашиглалтад байгаа агаарын хелгийг хүний амь нас хохироо, өмч хөрөнгө, хүрээлэн буй орчинд хохирол учруулахад ашиглах, биологийн, химийн, цемийн аливаа зэвсэг, тэсэрч дэлбэрэх болон цацраг идэвхт, тэдгээртэй адилтгах зүйлийг агаарын хелгээс цацах, хаях, тээвэрлэх, ийм төрлийн хууль бус үйлдлийг оролдлого хийх, заналхийлэх, үйлдэхэд дэмжлэг үзүүлэх, дэлгэрүүлэх зэрэг үйлдлийг гэмт хэрэгт тооцох, хуулийн дагуу хариуцлага хүлээлгэх, хэргийн харьяалал тогтоох, гэмт этгээдийг шилжүүлэх зохицуулалтыг тус тус тодорхой тусгасан.

1.2. Практик шаардлага

Монгол Улс нь Олон улсын иргэний нисэхийн байгууллагаас баталсан бодлого, стандарт, зөвлөмжийг хэрэгжүүлэх, гэрээ, конвенцод нэгдэх, аюулгүй ажиллагааны аудитад хамрагдах, бус нутагт хэрэгжүүлж байгаа хамтын ажиллагааны хөтөлбөр,

төсөл, уулзалт, семинар, хурал чуулган, сургалтад хамрагдах зэрээр "оролцогч" улсын байр суурийг хадгалж, олон улсын иргэний нисэхийн үйл хэрэгт оролцож байна.

"Олон улсын иргэний нисэхийн эсрэг хууль бус үйлдэлтэй тэмцэх тухай конвенц" нь "Иргэний нисэхийн аюулгүй байдлын эсрэг хууль бус үйлдлийг хориглох тухай" Монреалийн конвенц, түүний нэмэлт Протоколоос давуу хүчин чадалтай олон улсын гэрээ юм.

"Олон улсын иргэний нисэхийн эсрэг хууль бус үйлдэлтэй тэмцэх тухай конвенц" нь 2018 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн хүчин төгөлдөр мөрдөгдөж эхэлсэн багаад 34 улс гарын үсэг зурж, 23 улс соёрхон баталж, 19 улс нэгдэн орж, 1 улс хулээн зөвшөөрч, 1 улс батлаад байна.

Манай Улсын нутаг дэвсгэр дээгүүр үйлдэж буй нислэгийн тоо жилээс жилд өсөж, агаарын харилцаа өргөжин хөгжиж байна. Нислэгийн чиглэл нэмэгдэхийн хэрээр нисэх буудал, агаарын навигацийн төхөөрөмжүүдийн аюулгүй байдлыг хангах, иргэний нисэхийн болон нислэгийн аюулгүй байдлын хэм хэмжээг олон улсын жишиг түвшинд хүргэх шаардлага үүссэн.

Иймд Монгол Улсын иргэний нисэхийн салбарын аюулгүй байдлын стандартын төвшинг олон улсын шинэчлэн сайжруулсаар байгаа стандарт шаардлагад нийцүүлэх зорилгоор "Олон улсын иргэний нисэхийн эсрэг хууль бус үйлдэлтэй тэмцэх тухай конвенц"-д нэгдэн орох шаардлагатай байна.

Хоёр. Хуулийн төслийн ерөнхий бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээний талаар

"Олон улсын иргэний нисэхийн эсрэг хууль бус үйлдэлтэй тэмцэх тухай конвенц"-д нэгдэн орсныг соёрхон батлах тухай хуулийн төсөл нь нэг зүйтэй байна.

Гурав. Хуулийн төсөл батлагдсаны дараа үүсэж болох эдийн засаг, нийгэм, хууль эрх зүйн үр дагавар, тэдгээрийг шийдвэрлэх талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээ

Хуулийн төсөл батлагдсанаар Монгол Улс нь "Олон улсын иргэний нисэхийн эсрэг хууль бус үйлдэлтэй тэмцэх тухай конвенц"-ын Оролцогч улс болж, иргэний нисэхийн эсрэг хууль бус үйлдлээс урьдчилан сэргийлэх, тэмцэх, хариуцлага хүлээлгэх олон улсын хамтын ажиллагааны эрх зүйн хэм хэмжээг бэхжүүлэхэд хувь нэмрээ оруулах юм.

Хуулийн төсөл батлагдсанаар Монгол Улсад иргэний нисэхийн аюулгүй байдлын тогтолцоог сайжруулахад дэмжлэг болох багаад нийгэм, эдийн засгийн хөгжилд аливаа серег үр дагавар үзүүлэхгүй, улсын төсвээс нэмэлт зардал шаардагдахгүй болно.

Дөрөв. Хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль болон бусад хуультай хэрхэн уялдах, түүнийг хэрэгжүүлэхэд шинээр боловсруулах, хуульд нэмэлт өөрчлөлт оруулах, хүчингүй болсонд тооцох тухай хууль тогтоомжийн талаар

Хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хуульд нийцэж байгаа багаад нийцэж байгаа багаад хуулийн төсөлтэй холбогдуулан Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах шаардлагатай.

---оо---